

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ БАРИМТ БИЧИГ НЯГТЛАН ШАЛГАХ КОМИССЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Үндэсний аудитын газрын дэргэд Баримт бичиг нягтлан шалгах комисс байгуулан ажиллана.

2. Байгууллагын ББНШК-ын дүрэм, бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.

Хоёр. ББНШК –ын үндсэн зорилт, чиг үүрэг

2.1. ББНШКомисс нь баримтын үнэ шинийг нягтлан шалгах, архивын байнгын хадгалалтанд баримт сонгох, шилжүүлэхтэй холбогдсон ажлыг зохион байгуулах, ҮАГ-ын архивын хөмрөгийн нөхөн бүрдүүлэлтийн бодлого, чиглэлийг тодорхойлох үндсэн зорилтыг хэрэгжүүлнэ.

2.2. ББНКомисс нь дээрх үндсэн зорилтын хүрээнд дараах чиг үүрэгийн хэрэгжүүлнэ.

- байнга, түр хадгалах болон устгах хэргийг ялгах, сонгох ажлыг жил бүр зохион байгуулах

- баримт бичиг хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтын төслийг хянан хэлэлцэх, өөрчлөлт оруулах, батлах,

- төрийн архивт шилжүүлэх баримт бичгийн жагсаалтын төслийг хянан хэлэлцэх батлах,

- төрийн архивын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комисс-оос зөвлөгөө авч ажиллах,

- архив, албан хэрэг хөтлөлтийн талаар байгууллагын хэмжээнд дагаж мөрдөх арга зүйн баримт бичиг боловсруулахад оролцох, хэлэлцэх

Гурав. ББНШК-ын ажлын зохион байгуулалт

3.1. ББНШК нь 3-6 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд комиссын даргаар байгууллагын Ерөнхий менежерийг, нарийн бичгийн даргаар архивын ажилтанг, гишүүдэд нэгжийн дарга, захирал, холбогдох ажилтнуудыг томилно.

3.2. Комиссын хурлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу жилд 2-оос доошгүй удаа, гишүүдийн гуравны хоёроос дээш хувийн ирцтэйгээр зохион байгуулж, асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Шаардлагатай асуудлаар комиссын хурлыг хугацаанаас нь өмнө зарлан хуралдуулж болно.

3.3.Хурлаар хэлэлцэх асуудлыг комиссын дарга, нарийн бичгийн дарга нар зохион байгуулж, 1-3 хоногийн өмнө гишүүдэд тарааж танилцуулж саналыг нь авсан байна.

3.4.Хурлын явцад нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтөлж баталгаажуулна.

3.5.Архивт байнгын хадгалалтанд баримт сонгохдоо зохих төрийн архиваас зөвлөгөө авна.

3.6.Архивын баримтыг төрийн архивын дэргэдэх БНШАЗКомиссын хурлын шийдвэрийг үндэслэн байгууллагын даргын шийдвэрээр устгана.